

2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2022.05.19

Дугаар 31

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт ирүүлэх хугацаа	Биелэлт
1	Баригдаж удаагүй хэдий ч чанар, ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилгуудад улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах, шаардлагатай тохиолдолд харьяаллын дагуу аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэх арга хэмжээ авах	МХГ-ын дарга Х.Бауыржан	V/19	<p>2010 оноос хойш баригдсан их засвар болон урсгал засвар шаардсан дараах барилга байгууламжууд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аймгийн спорт хорооны барилга- 2021 онд тус барилгын 1 давхрын бэлтгэлийн, 00-ын өрөө болон ажилчдын өрөө тасалгаануудын хананууд цуурч ан цав үүссэн ба хананууд суулт өгч цөмөрсөн тул манай байгууллагад хандаж дүгнэлт гаргуулсан. 2. Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга 2013 онд ашиглалтад орсноос хойш чанар байдалд дүгнэлт хүссэн тухай тус цэцэрлэгийн эрхлэгчээс удаа дараа хүсэлт ирж байсан ба хоёр удаагийн дүгнэлт, шаардлагаар салхинд хийссэн дээвэр болон бусад дотоод засал, халаалтын шугамуудад засвар хийлгэж байсан. 2022 оны 4 дүгээр сард улсын байцаагчийн үйл ажиллагааг түр зогсоох акт гарсан. 3. Аймгийн ЕБ-ын 2-р сургуулийн 1 давхрын коридор цөмөрч манай байгууллагад хандаж дүгнэлт гаргуулж, гүйцэтгэгч байгууллагаар засуулсан ба 2022 онд 1 давхрын коридор болон 00-ын өрөөний шалнууд цөмөрч бас засуулсан. 4. Аймгийн номын сангийн эрчлэгчийн хүсэлтийн дагуу аймгийн нийтийн номын сангийн барилгын чанар байдалд дүгнэлт гаргуулж, барилгад хүчитгэл хийж ашиглалтын хэвийн горимд оруулсан 5. Дэлүүн сумын “Болашах” багийн сургуулийн захирлын 2021 оны 3 дугаар ирүүлсэн албан хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж үйл ажиллагаа ашиглалтыг түр зогсоох акт хүргүүлсэн. Барилгыг барихад геологийн судалгаа хийгдээгүй, магадлалд орсон баталгаат зураг төсөлгүй байна. 6. Цэнгэл сумын “Соёлын төвийн барилга”-д хяналт шалгалт хийж дүгнэлт хүргүүлсэн. Барилгын хучилтаас байнгын ус нэвчдэг тул ханануудын будаг өнгө үзэмжээ алдсан ба цахилгаан монтажийн зарим хэсэг гэмтэлтэй болсон

				<p>байна.</p> <p>7.Буянт сумын “Соёлын төв”-ийн эрхлэгчийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, барилгын үзвэрийн хэсгийн дээврээс ус нэвчдэг тайзны арын хэсгийн даацын бус хананд ан цав үүссэн ба бүжгийн өрөө болон хэсэг өрөө тасалгааны даацын бус ханануудад ан цав үүссэн ажилчдын ажиллах эрүүл аюулгүй орчин бүрдэхгүй байгаа тул барилгын зөрчилтэй хэсгийн үйл ажиллагаа ашиглалтыг түр зогсоох хэсэгчилсэн улсын байцагчийн акт хүргүүлсэн болно.</p> <p>8.Буянт сумын халуун усны барилгад хяналт шалгалт хийхэд өрөө тасалгаануудад агааржуулалтын систем тавигдаагүйн улмаас ханануудын будаг зарим хэсгийн шавардлага ховхорч унасан байна.</p>
2	Аймгийн төвд зохион байгуулагдах Элсэлтийн Ерөнхий шалгалтын сарын вакуумжуулсан сургалтад харьяа нутаг дэвсгэрийнхээ төгсөх ангийн сурагчдыг бүрэн хамруулах арга хэмжээ авах	Сумдын Засаг дарга нар	V/19	Элсэлтийн Ерөнхий шалгалтын сарын вакуумжуулсан сургалтад харьяа нутаг дэвсгэрийнхээ төгсөх ангийн сурагчдыг бүрэн хамруулах арга хэмжээ авч ажиллаж байна гэх биелэлтийг сумдаас ирүүлжээ.
3	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод таригдсан газруудад гүний худаг гаргах, цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах	ХБТХОХ-ийн дарга Х.Анар Өлгий сумын ЗД Д.Есболат БОАЖГ-ын дарга Ш.Марат СДОА-н дарга Х.Есенбол	V/19	Ажлын хэсэг газар дээр нь ажиллаж, хуучин Хүрлээгийн усны сувгийг төсвийн мэргэжлийн байгууллагаар сэргээн засварлуулахаар болов. Мөн намрын цагт тухайн ойжуулалтын талбайг услах зориулалтаар цахилгааны усны помп ажиллуулахаар шийдвэрлэсэн болно.
4	Баяннуур сумын сургуулийн спорт заал, Сагсай сумын гүний худаг, Алтанцөгц сумын усалгааны системийг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн Нар-Маржан ХХК-ний ажлын гүйцэтгэлтэй танилцах, дүгнэлт гаргах	МХГ-ын дарга Х.Бауыржан ГХБХБГ-ын дарга К.Болат	V/19	ГХБХБГ: -Баяннуур сумын спорт заалны барилга байгууламжид ГХБХБГ, МХГ хамтран хяналт шалгалт хийж, холбогдох үүрэг чиглэлийг өгсөн. -Сагсай суманд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 25 сая төгрөгийн өртөгтэй Хар уулын гүний худагны хувьд газар дээр нь очиж танилцсан. Барилгын далд ажлын актаар 96м-ийн гүнтэй өрөмдмөл худаг байгаа бөгөөд 2020 онд ХХААГ-аас мэргэжлийн байгууллага ашиглалтад авсан. Улсын комисс ажиллаагүй байна. Ашиглах явцад тог зохицуулагч контрол багаж шатсан

			<p>үүнийг гүйцэтгэгч байгууллага засаж өгсөн. Харин ашиглагч байгууллага техникийн нөхцөлд байхгүй пат-пад мотор авахаар шаардсан байх бөгөөд үүнийг гүйцэтгэгч байгууллага сайн санаа гаргаж пат-пад мотор олгохоор шийдвэр гаргажээ. Хил гаальтай холбоотой уг моторыг нийлүүлж чадаагүй байна. Усны гарцын хувьд ямар нэгэн асуудал байхгүй.</p> <p>-Алтанцөгц суманд 39,4 сая төгрөгний өртөг бүхий хуучин усалгааны системийг сэргээн засварлах он дамжсан ажил байна. Гэрээний хугацаа 2022 оны 06 дугаар сарын 01-нд дуусах ёстой. Энэ хугацаанд ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. Нийт 4,5 км урттай. 45 хаалт хийсэн, 500м газрыг хэсэгчилсэн чулуугаар бүрсэн байна. Зургийн дагуу хийгдэж байна.</p> <p>МХГ: 1.Нармаржан ХХК-ийн сургуулийн спорт заалны их засварын ажил:</p> <p>Баяннуур сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн албан бичгээр тус сумын сургуулийн спорт заалны их засвар чанаргүй хийгдсэн зохих журмын дагуу шалгуулах тухай хүсэлтийн мөрөөр тус сумын сургуулийн спорт заалны их засварын ажлын чанар байдалд нь талавлагаат бус хяналт шалгалт хийхэд 6 төрийн зөрчил илэрсэн тул улсын байцаагчийн зөрчил арилгуулах тухай хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Улсын байцаагчийн албан шаардлагад заасан хугацааны дотор хариу ирүүлээгүй тул Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн торгуулийн арга хэмжээ авсан. Гүйцэтгэгч Нармаржан компани нь гарсан зөрчлүүдийг их засварын ажлын баталгаат хугацаанд багтаан зөрчлийг арилгах тухай албан бичгээр хариу ирүүлсэн. Энэ тухай Баяннуур сумын Засаг дарга болон Сургуулийн захиралд биечлэн танилцуулсан. / Тус сургуулийн их засварын ажлыг хүлээн авах ажлын комиссын бүрэлдэхүүнд Мэргэжлийн хяналтын газраас холбогдох байцаагч ороогүй болохыг дурдаж байна/</p> <p>2. Алтанцөгц сумын услалтын систем:</p> <p>Алтанцөгц сумын услалтын системийн угсралтын ажил нь 2021 онд эхэлсэн бөгөөд тухайн жилд авсан санхүүжилтийн дагуу ажлаа хийсэн ба үлдсэн санхүүжилтийг 2022 оны</p>
--	--	--	---

				<p>төсвөөс санхүүжүүлэхээр болсон тул санхүүжилт хийгдсэний дараа услалтын системийн угсралтын ажлыг дуусгахаар төлөвлөж байгаа юм байна. Уг ажлын гүйцэтгэлийн чанар байдалд нь Барилга захиалагчийн албанаас захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна. Энэ тухай тодруулж асуухад одоогийн байдлаар чанаргүй гүйцэтгэсэн гэх мэдээлэл ирүүлээгүй болно.</p> <p>3. Сагсай сумын гүний худагны ажил:</p> <p>Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу Сагсай сумд баригдсан гүний худагны ажлын гүйцэтгэлийн талаар аймгийн Хөдөө аж ахуйн газрын холбогдох мэргэжилтнээс /Айдын/ асууж тодруулахад Сагсай сумын гүний худаг гаргах ажил улсын хөрөнгө оруулалтаар 2019 онд баригдсан байна. Ажил гүйцэтгэх гэрээг Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамтай байгуулсан ба баригдах үед захиалагчийн хяналтыг яамнаас холбогдох мэргэжилтэн хяналт тавьсан бөгөөд давхар Хөдөө аж ахуйн газраас хяналт тавигдсан байна. Тухайн үед худгийг ашиглалтад оруулах комисс ажиллахад худагны мотор, насос нь зураг төсөлд заасан шаардлагыг хангаагүй бөгөөд ус гарах үед ус тасалдах юм байна гэсэн шалтгаанаар комисс хүлээн авахаас татгалзсан байна. Үүнээс хойш Хөдөө аж ахуйн газраас удаа дараа худгийг ашиглалтад оруулах, гарсан зөрчлийг арилгуулах зорилгоор албан тоотоор хандахад хариу хүргүүлээгүй гэсэн мэдээлэл өгсөн</p>
5	Сумдын эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах материалаа бүрэн бүрдүүлэх, цахимд бүртгэх арга хэмжээг хариуцлагатай зохион байгуулах, санхүүжилт авах боломжийг хангаж ажиллах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах	ЭМГ-ын дарга Н.Сакен Сумдын Засаг дарга нар Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нар	V/19	2022.05.16-05.17-ны өдрүүдэд “ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭЧЛЭЛ, СТРАТЕГИЙН ХУДАЛДАН АВАЛТ, ЭМНЭЛГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫН ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ” чиглэлээр сургалт зохион байгуулж, сургалтад аймгийн анхан болон лавлагаа шатлалын удирдлагууд, нягтлан бодогч, дүн бүртгэгч нийт 59 албан хаагчийг хамруулан, арга зүйгээр хангаж ажиллав.
6	Дэлүүн, Булган сумын хоорондох Хар усны гүүрийг яаралтай засварлуулах холбогдох арга хэмжээг авах	ГХБХБГ-ын дарга К.Болат	V/19	Хамааралгүй гэх биелэлтийг ирүүлжээ.

7	Толбо сумын зам дагуух хогийн цэгийн цэвэрлэгээг тогтмол хяналтад авах, дэмжлэг үзүүлж ажиллах	Толбо сумын ЗДҮТОГ Т.Досымбек ХХҮГ-ын дарга А.Галия	V/19	ХХҮГ: Толбо сумын зам дагуух хог цэвэрлэх төслийг хүлээж авсан. 2022 оны 05-р сарын 22-ны өдөр ажлыг нь эхлүүлэхээр бэлтгэл ажил хангаж ажиллаж байна.
---	--	---	------	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР